



“ЭРДЭНЭС МОНГОЛ” НЭГДЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2024–2028

Улаанбаатар хот 2024

Зураг 4. Нөөцийн удирдлагын стратегийн ангилал



Нөөцийн удирдлагын стратегийг дараах зорилго, зорилтоор хэрэгжүүлнэ.

Зорилт	Үйл ажиллагаа
Мэдээллийн технологийн нэгдсэн систем, шилдэг туршлагыг нэвтрүүлнэ	- Бизнесийн үйл ажиллагаандаа дэвшилтэт технологийн хэрэглээг нэмэгдүүлж, цахим шилжилтийг хурдасган, орчин үеийн дэвшилтэт технологийг түлхүү нэвтрүүлнэ. - Нэгдлийн хэмжээнд нэгдсэн ERP систем нэвтрүүлж, нэгдсэн нөөцийн удирдлагын тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ. - Бодит цагийн горимд өгөгдөл цуглуулах, түүн дээр дүн шинжилгээ хийж шийдвэр гаргахад ашиглана. - Юмсын интернэт (IoT), дэвшилтэт технологи ашиглан үйлдвэрлэлийн процессыг автоматжуулан зардал бууруулж, аюулгүй ажиллагааг сайжруулна.
Санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ	- Нэгдлийн хэмжээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн бодлогыг тодорхойлж, санхүүгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ. - Хөрөнгө, эх үүсвэр, нөөцийн удирдлагыг оновчилж нэгдлийн төслийн санхүүжилт, эх үүсвэрийг тогтвортой удирдана. - Дэвшилтэт технологи бүхий санхүү, төлөвлөлт, хяналт, удирдлагын нэгдсэн системийг нэгдлийн хэмжээнд нэвтрүүлнэ.

Бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагааг нэгдсэн тогтолцоо, бодлогоор хангана	• Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой нөөцийн нэр төрлийг тодорхойлж, ханган нийлүүлэлтийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэнэ. • Нэгдлийн дунд хугацааны нөөцийн хэрэгцээг тодорхойлж, Төрийн худалдан авах ажиллагааны ЦАХИМ дэлгүүрээс стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг хялбаршуулсан горимоор түргэн шуурхай худалдан авах нөхцөлийг бүрдүүлж, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бий болгоно. • Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн ашиглалтын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, чанар стандартын шаардлага хангасан бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бий болгоно.
Хүний нөөцийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ	• Нэгдлийн ажилтнуудыг сэлгэн ажиллуулах замаар мэдлэг, туршлага солилцох боломжийг бий болгоно. • Нэгдлийн бүрэлдэхүүний байгууллагууд хүний нөөцийг оновчтой ашиглах, туршлага солилцох боломжийг нэмэгдүүлнэ. • Мэргэжлийн өндөр ур чадвар, дадлага туршлага бүхий ажилтныг нэгдлийн харьяа байгууллагуудад ажиллуулж, мэдлэгээ хуваалцдаг тогтолцоог бий болгоно.

Мэдээллийн технологийн нэгдсэн систем, шилдэг туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд:

Эрдэнэс Монгол нэгдэл нь тогтвортой хөгжил, хариуцлагатай уул уурхайн зарчмыг баримталж, өөрийн эрхэм зорилгодоо хүрэхийн тулд уурхайн олборлолт, боловсруулалт, үйлдвэрлэл, тээвэр логистикийн үйл ажиллагаандаа олон улсын тэргүүн туршлага, дэвшилтэт технологийг шингээсэн дэлхийд тэргүүлэгч ERP системийг нэгдлийн хэмжээнд мэдээллийн нэгдсэн платформ болгон ашиглана. Нэгдлийн хэмжээнд нэгдсэн ERP системийг нэвтрүүлснээр:



Зураг 5. ERP системийн бүтэц

- Бодит тоон мэдээлэл дээр үндэслэн цуглуулсан өгөгдөлд дүн шинжилгээ хийж стратегийн болон тактикийн шийдвэр гаргахад туслахаас гадна, шинэ боломж болон эрсдэлээ тодорхойлж удирдах боломжийг олгоно.
- Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг сайжруулах: ERP систем нэвтрүүлснээр шаардлагатай сургалт, зааварчилгаа, бодит цагийн үнэн зөв мэдээллээр ажилчдыг хангаснаар учирч болзошгүй эрсдэлийг бууруулж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулна. Мөн усны нөөцийн удирдлага, хог хаягдлын удирдлага, хүлэмжийн хийн удирдлагын модулийг ашиглан уурхайн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгана.
- Бизнес процессыг автоматжуулж хялбарчлах: Дэлхийн тэргүүн туршлага стандартыг нэвтрүүлж, бизнесийн процессыг автоматжуулж хялбарчлах, улмаар олон төрлийн үйл ажиллагааг нэгтгэж, ажлын давхардлыг багасгаж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.

